

EMPOWERED BY CECI 2.0

БИЗНЕСЭЭ НОГООН БОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ

2026 он

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

ЖДБ эрхлэгчдийг тогтвортой хөгжлийн бодлогод уриалах, үйл ажиллагаагаа байгальд ээлтэй "Ногоон бизнес" рүү шилжүүлэхэд нь шаардлагатай мэдлэг мэдээллээр хангах, байгаль орчин болон нийгэмд эерэг нөлөө үзүүлэх хөтөлбөрийн манлайлагч төсөлд ногоон шилжилтийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт олгох юм.

Зохион байгуулагч: Си И Си Инвестмент ББСБ ХХК

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Хамрах хүрээ: Бизнесийнхээ үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцүүлэхэд санхүүжилт хэрэгтэй, ТХЗ-ын санхүүжилтийн таксономи эсвэл БОНЗ (Байгаль орчин, нийгэм, засаглал)-ын чиглэлээр санаачилга гаргаж буй жижиг, дунд бизнес эрхлэгчид болон харилцагчид.

2.2 Бизнесийн болон санхүүгийн ерөнхий шаардлага:

- Үндсэн чиглэлээрээ сүүлийн 6 сараас доошгүй хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх.
- Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тусгай зөвшөөрөл, лиценз, гэрчилгээтэй байх бөгөөд хуулийн дагуу хүчин төгөлдөр байх.
- Монголбанкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн түүхгүй байх, мөн Татварын ерөнхий газарт хугацаа хэтэрсэн татварын өргүй байх.
- Хөтөлбөрийн хориглох чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэггүй байх.
- Зээлийн дүнг бүрэн хангахуйц барьцаа хөрөнгөтэй байх.

2.3 Хориглох чиглэлүүд:

Дараах бизнесийг хөтөлбөрт хамруулахгүй болно.

- Хавсралт 1-д заасан БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний дагуу хориглосон буюу байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа эрхлэгчид.
- ББСБ, ХЗХ зэрэг ижил төстэй санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ БОЛОН ХУГАЦАА

Хөтөлбөрийн бүртгэл /2026.09.14 хүртэл/	
Хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй бизнес эрхлэгчдийн өргөдлийг хүлээн авч, анхан шатны шалгуурт нийцсэн оролцогчдыг сонгож баталгаажуулна.	Цахим бүртгэлийн анкет бөглөх.
Чадавхжуулах сургалт /2026.09.16-18 өдрүүдэд/	
Бизнесүүд төлөвлөгөөгөө боловсруулж эхлэхээс өмнө мэргэжлийн экспертнийг урьж 2 удаагийн сургалт орно.	Сургалт 1. Ногоон бизнес ба БОНЗ-ын суурь ойлголт - Тогтвортой хөгжил гэж юу вэ, бизнесийг яагаад ногоон болгох шаардлагатай вэ, БОНЗ-ын зарчмыг үйл ажиллагаанд хэрхэн тусгах вэ.

	Сургалт 2. Монгол Улсын Ногоон таксономийн суурь ойлголт - Ногоон таксономийн зорилго, ангилал, шалгуур болон төсөл, бизнесийн үйл ажиллагааны нийцлийг урьдчилан тодорхойлох үндсэн аргачлал.
Ногоон бизнес төлөвлөгөө боловсруулах /2026.09.19-2026.09.30 хүртэл/	
Сургалтын дараа бизнесүүд олж авсан мэдлэгтээ тулгуурлан өөрийн компанийг "Ногоон бизнес" болгох нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж танилцуулна.	<i>Төсөлд тусгагдсан ажлууд нь Монгол Улсын Ногоон таксономийн аль бүлэг, заалттай уялдаж байгааг тодорхой заасан байх шаардлагатай.</i>
Төслийн сонгон шалгаруулалт /2026.10.08 өдөр/	
Оролцогчдын ирүүлсэн "Ногоон бизнес төлөвлөгөө" болон бэлэн байдлыг шалгаруулалтын комисс үнэлнэ.	- Ирүүлсэн төслүүдийг нийгэм болон байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон бодит хэрэгжих боломжоор нь үнэлэх. - Шалгуурыг хангасан шилдэг төслийг шалгаруулж, ногоон шилжилтийн зардлын санхүүжүүлнэ.

ДӨРӨВ. ШАЛГАРУУЛАЛТ

4.1 Ерөнхий шаардлага

- Хөтөлбөрийн хамрах хүрээнд нийцсэн байх;
- Хориглосон үйл ажиллагаанд хамаарахгүй байх;
- Монгол Улсын Ногоон таксономийн тодорхой ангилал, шалгууртай уялдсан байх;
- Санхүүжилтийн зориулалт болон төсөв нь тодорхой байх;
- Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах 2 удаагийн сургалтад төлөвлөгөө боловсруулагч биечлэн хамрагдсан байх.

4.2 Онооны үнэлгээ.

Урьдчилсан шаардлагыг хангасан төлөвлөгөөг дараах шалгуураар нийт 100 хүртэл оноогоор үнэлнэ:

- Байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөл – 30 оноо;
- Монгол Улсын Ногоон таксономийн нийцэл – 20 оноо;
- Төлөвлөгөөний бодит хэрэгжих боломж – 25 оноо;
- Үр дүнгийн хэмжигдэхүйц байдал – 15 оноо;
- Удирдлагын оролцоо болон урт хугацаанд тогтвортой хэрэгжих боломж – 10 оноо.

Нийт үнэлгээний 70-аас доошгүй оноо авсан төслүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй 1 төслийг санхүүжилтийн боломж, зээлийн судалгаа болон сонгон шалгаруулах комиссын шийдвэрт үндэслэн шалгаруулна. Шалгарсан төсөл нь зээлийн ерөнхий болон тусгай шаардлагыг давхар хангасан байна.

4.3 Шалгаруулалтын комисс

Төслийн сонгон шалгаруулалтыг Си И Си Инвестмент ББСБ-ын удирдлагын баг болон Монголын Тогтвортой Санхүүжилтийн (ТОС) холбооны хөндлөнгийн, хараат бус мэргэжлийн экспертээс бүрдсэн хамтарсан комисс зохион байгуулна.

ТАВ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Шалгарсан шилдэг нэг бизнест **ногоон шилжилтийн хөнгөлөлттэй зээл** олгоно. (Энэхүү зээлийн зориулалт нь бизнесээ ногоон болгох буюу хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан төлөвлөгөөний дагуу зарцуулагдах ёстой).

Ногоон шилжилтийн хөнгөлөлттэй зээлийн нөхцөл

Нөхцөл		Хэмжээ
Зээлийн дээд хэмжээ		50 сая
Хугацаа		36 сар
Сарын хүү, %	Эхний 12 сар	1.0% (Жилийн 12%)
	13-36 дах сард	1.5% (Жилийн 18%)
Үйлчилгээний шимтгэл		1.00%
Барьцаа		Ирээдүйд орж ирэх орлого, Хөдлөх болон үл хөдлөх

ЗУРГАА. САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ БА ХЯНАЛТ

Олгогдох хөнгөлөлттэй санхүүжилт нь зориулалтын бус зарцуулалтаас сэргийлэх хатуу хяналттай байна.

- Ногоон шилжилтийн санхүүжилтийн зориулалт:** Олгогдох энэхүү санхүүжилт нь зөвхөн тухайн бизнесийг ногоон болгох, ТХЗ-ын санхүүжилтийн таксономитой холбоотой шууд зардлуудыг санхүүжүүлэхэд ашиглагдах ба өөр зүйлд зарцуулахгүй байх.
- Сар бүрийн тайлагнал:** Зээлдэгч нь батлагдсан төлөвлөгөөний дагуу санхүүжилтийг хэрхэн зарцуулсан, ямар тоног төхөөрөмж худалдан авсан талаарх санхүүгийн баримт болон үр дүнгийн тайланг сар бүр гаргаж өгнө.
- Биечилсэн хяналт:** Санхүүжилт олгосноос хойш 3 сар тутамд тухайн бизнесийн үйл ажиллагаатай газар дээр нь биечлэн очиж танилцаж, ногоон төлөвлөгөөний бодит гүйцэтгэлийг шалгана.
- Зөрчлийн хариуцлага:** Хэрэв санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулсан, эсвэл хяналт шалгалтаар төлөвлөгөө хэрэгжээгүй нь тогтоогдвол ББСБ-ын зүгээс зээлийн хүүгийн хөнгөлөлтийг шууд цуцалж, зээлийн хугацаанд гарсан хүүгийн хөнгөлөлт болон хөтөлбөрийн хүрээнд гарсан зардлуудыг бүрэн төлүүлнэ.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ДҮРЭМ

- Хөтөлбөр эхлэхийн өмнө цахимаар бүртгүүлсэн байна. Цахимаар бүртгүүлсэн бизнесүүдээс урьдчилсан шалгаруулалт хийж, сонгогдсон оролцогчид хөтөлбөрт хамрагдана.
- Хөтөлбөрийн үйл ажиллагааны үеэр аливаа хэлбэрээр бусдын нэр төрд халдах, үг хэлээр доромжлох, ялгаварлан гадуурхах, маргаан үүсгэх, бусдын оюуны өмч болон төслийн санааг хуулбарлахыг хатуу хориглоно. Дээрх ёс зүйн зөрчлийг гаргасан тохиолдолд хөтөлбөрөөс шууд хасах арга хэмжээ авна.
- Хөтөлбөрт оролцогчид нь манай байгууллагын PR болон маркетингийн үйл ажиллагаанд (видео контент, ярилцлага, олон нийтийн сүлжээний мэдээлэлд) нээлттэй, идэвхтэй оролцох үүрэг хүлээнэ.
- Шалгарсан тохиолдолд байгууллагынхаа ногоон шилжилтийг "Амжилтын түүх" болгон бусадд үлгэрлэж, хөтөлбөрийн үр дүнг хэмжих биечилсэн хяналтад хамтарч ажиллана. Мөн хөтөлбөр хэрэгжсэнээс хойшхи 3 жилийн хугацаанд "Си И Си Инвестмент" ББСБ-ын ногоон бизнесийг сурталчлах PR, контент арга хэмжээнд нээлттэй хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

Холбоо барих: Та 77725511 утсаар болон suvd-ochir.e@upc.mn мэйл хаягаар холбогдоно уу.

Хавсралт 1: Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт (Монгол Улсын Тогтвортой санхүүгийн зарчмууд).

1. Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсаас даалгасан олон улсын хууль тогтоомж, конвенц, хэлэлцээрээр хориглосон үйл ажиллагаа;
2. Сэтгэгдэл нөлөөлөх ургамал тариалах, хуульд заагаагүй бол мансууруулах бодис үйлдвэрлэх, тээвэрлэх, худалдаалах;
3. Зохисгүй буюу хууль бус мөрийтэй тоглоом, казиногийн бизнес;
4. Садар самуун сурталчилсан үйлдлийг маркетинг, дэмжих, зохион байгуулах;
5. Албадан хөдөлмөрийн хор хөнөөлтэй, мөлжлөгийн хэлбэр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, ялгаварлан гадуурхалт, ажилчдын эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр хийх эрхийг хуульд заасан аливаа үйл ажиллагаа;
6. Буу, дайны зэвсгийн үйлдвэрлэл, худалдаа;
7. Олон түвшний маркетинг, пирамид схемээр ашиг олох;
8. Холбогдох улс орнуудын зохих зөвшөөрөл, зөвшөөрөлгүйгээр экспортлох, импортлох, улс орон даяар худалдаа хийх;
9. Олон улсын болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт байрлах үйл ажиллагаа;
10. Биологийн олон янз байдал, түүх, соёлын өвийг хамгаалах тухай олон улсын конвенц, хэлэлцээрээр хориглосон үйл ажиллагаа;
11. Асбест болон түүнийг агуулсан аливаа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, ашиглалт;
12. ПХБ-Полихлорт бифенил агуулсан аливаа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа;
13. Олон улсад хориглосон озон задлах бодис агуулсан бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа;
14. Олон улсын хэмжээнд хориглосон эм, шахмал, шавьж устгах бодис болон бусад хортой бодис үйлдвэрлэх, худалдаалах;
15. CITES-ээс хориглосон зэрлэг амьтан, ургамлын сорьцын худалдаа;
16. Тогтворгүй загас агнуурын аргууд (жишээлбэл, тэсэлгээний загас агнуур)
17. Олон улсад хориглосон хаягдал материалыг тээвэрлэх, устгах;
18. Хамгаалалтын өндөр ач холбогдолтой ойн бүс нутагт мод бэлтгэх (жишээлбэл, Хангайн ой) болон тусгай хамгаалалттай газартай холбоотой ойн болон мод бэлтгэлийн тоног төхөөрөмжийн худалдаа;
19. Тогтвортой менежменттэй ойгоос гараагүй мод бэлтгэх, мод, ойн бүтээгдэхүүний худалдаа;
20. Роттердамын конвенц болон Стокгольмын конвенцид заасны дагуу хасагдсан болон хориглосон зүйлс